



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/194-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ч.Цэрэннадмид Утас: 95112689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	
Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал.....	16
3.4. Материаллаг байдал.....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Албан шаардлага, Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
НА	Нотлох ажил
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТҮШИГ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Х.БЯМБАЦОО ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2025.02.25 № СЭА-2022/194-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,645,172.54	78,092,712.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	61,645,172.54	78,092,712.54
351	Түүхий эд материал	-	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	28,000.00	2,054,610.00
354	Хангамжийн материал	61,617,172.54	76,038,102.54
35420	Аж ахуйн материал	36,254,060.00	35,542,940.00
35460	Хүнсний материал	-	3,414,150.00
35470	Бусад хангамжийн материал	25,363,112.54	37,081,012.54
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,076,264,443.26	2,171,879,429.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,076,264,443.26	2,171,879,429.18
392	Биет хөрөнгө	2,059,010,509.90	2,154,875,495.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,813,859,903.00	1,813,859,903.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(28,658,288.40)	(72,386,641.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,072,395.98)	(11,164,583.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	268,425,003.60	285,367,403.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(187,232,772.60)	(57,599,775.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,905,759.25	78,505,759.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,191,580.42)	(35,421,795.10)
39209	Зам, гүүрийн байгууламж	18,750,000.00	18,750,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(11,787,500.40)	(13,968,750.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,149,500.00	19,149,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,652,456.64)	(2,478,684.96)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	83,356,389.00	83,356,389.00
39217	Ном	32,596,449.49	34,344,272.29
393	Биет бус хөрөнгө	17,253,933.36	17,003,933.40
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(166,666.64)	(416,666.60)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,170,600.00	16,170,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,137,909,615.80	2,249,972,141.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,137,909,615.80	2,249,972,141.72
51	Засгийн газрын хувь оролцоо	2,137,909,615.80	2,249,972,141.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	579,511,739.58	579,511,739.58
51101	Өмч: - төрийн	579,511,739.58	579,511,739.58
512	Хуримтлагдсан үр дүн	965,386,882.08	1,077,449,408.00
51210	Өмнөх үеийн үр дүн	965,386,882.08	965,386,882.08
51220	Тайлант үеийн үр дүн	-	112,062,525.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	593,010,994.14	593,010,994.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,137,909,615.80	2,249,972,141.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,393,555,660.14	1,035,860,857.97
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,508,298,443.74	170,832,766.80
120	Нийтлэг татварын бус орлого	1,508,298,443.74	170,832,766.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,621,005.91	143,983,098.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,621,005.91	143,983,098.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,496,602,365.29	10,690,222.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	8,075,072.54	16,159,446.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	885,257,216.40	865,028,091.17
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	785,059,200.00	730,737,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	763,529,200.00	730,737,400.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	21,530,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,530,000.00	1,638,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	595,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,530,000.00	1,043,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	78,668,016.40	132,652,591.17
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	78,668,016.40	132,652,591.17
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	887,778,677.55	923,798,332.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	887,778,677.55	923,798,332.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	783,336,787.18	890,838,786.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	545,680,097.33	565,028,908.77
210101	Үндсэн цалин	362,750,676.88	316,976,072.57
210102	Нэмэгдэл	132,102,518.45	215,431,608.00
210104	Урамшуулал	50,826,902.00	32,621,228.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,779,536.30	74,399,635.29
210201	Тэтгэврийн даатгал	48,502,242.55	52,061,722.72
210202	Тэтгэмжийн даатгал	5,485,773.11	5,686,527.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,321,411.63	4,529,362.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,042,738.77	1,101,902.37
210205	Эрүүл мэндийн даатгал	10,427,370.24	11,020,120.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,668,016.40	132,578,791.17
210301	Гэрэл, цахилгаан	5,475,765.40	10,389,736.17
210302	Түлш, халаалт	73,152,251.00	121,874,355.00
210303	Цэвэр, бохир ус	40,000.00	314,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,158,728.60	17,959,120.00
210401	Бичиг хэрэг	189,800.00	457,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,447,000.00	2,420,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	239,800.00	537,500.00
210404	Ном, хэвлэл	151,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,525,060.00	2,311,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,257,300.00	1,773,300.00
210408	Бараа материал акталсны зардал	16,348,568.60	10,459,420.00
2105	Нормативт зардал	17,126,036.00	23,242,096.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	262,700.00	532,246.00
210502	Хоол, хүнс	16,088,736.00	21,937,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	774,600.00	771,900.00

Сэлэнгэ аймгийн Түшиг сум дахь Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,336,600.00	1,354,400.00
210604	Урсгал засвар	4,336,600.00	1,354,400.00
2107	Томилолт, зочны зардал	172,600.00	182,900.00
210702	Дотоод албан томилолт	172,600.00	182,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	793,200.00	2,597,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	217,200.00	1,733,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	864,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,621,972.55	73,495,134.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,386,800.00	1,836,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,435,172.55	71,658,334.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,441,890.37	32,959,545.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,951,200.00	18,294,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,151,200.00	17,794,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	94,490,690.37	14,664,745.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,490,690.37	14,664,745.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,505,776,982.59	112,062,525.92
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,505,776,982.59	112,062,525.92

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	(493,709,094.60)		678,813,639.12
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,459,095,976.68		1,459,095,976.68
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	965,386,882.08)		2,137,909,615.80
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	965,386,882.08)		2,137,909,615.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	112,062,525.92		112,062,525.92
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	1,077,449,408.00	-	2,249,972,141.72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	885,257,216.40	865,028,091.17
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	885,257,216.40	865,028,091.17
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	785,059,200.00	730,737,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	763,529,200.00	730,737,400.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	21,530,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,530,000.00	1,638,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		595,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,530,000.00	1,043,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	78,668,016.40	132,652,591.17
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	78,668,016.40	132,652,591.17
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	840,262,216.40	852,428,091.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	840,262,216.40	852,428,091.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	736,684,526.03	817,266,435.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	547,656,447.33	565,028,908.77
210101	Үндсэн цалин	364,727,026.88	316,976,072.57
210102	Нэмэгдэл	132,102,518.45	215,431,608.00
210104	Урамшуулал	50,826,902.00	32,621,228.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,803,186.30	74,399,635.29
210201	Тэтгэврийн даатгал	46,525,892.55	52,061,722.72
210202	Тэтгэмжийн даатгал	5,485,773.11	5,686,527.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,321,411.63	4,529,362.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,042,738.77	1,101,902.37
210205	Эрүүл мэндийн даатгал	10,427,370.24	11,020,120.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,668,016.40	132,652,591.17
210301	Гэрэл, цахилгаан	5,475,765.40	10,389,736.17
210302	Түлш, халаалт	73,152,251.00	121,874,355.00
210303	Цэвэр, бохир ус	40,000.00	388,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,648,600.00	7,737,700.00
210401	Бичиг хэрэг	255,400.00	457,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,447,000.00	2,467,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	239,800.00	537,500.00
210404	Ном, хэвлэл	151,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,040,500.00	1,903,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,514,700.00	2,371,600.00
2105	Нормативт зардал	21,845,276.00	30,747,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	262,700.00	198,700.00
210502	Хоол, хүнс	14,807,976.00	25,176,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,774,600.00	5,371,900.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,291,600.00	2,204,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	850,000.00
210602	Тавилга	515,000.00	-
210604	Урсгал засвар	2,776,600.00	1,354,400.00
2107	Томилолт, зочны зардал	172,600.00	182,900.00
210702	Дотоод албан томилолт	172,600.00	182,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,477,600.00	2,597,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	651,600.00	1,733,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	864,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,121,200.00	1,715,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,321,200.00	1,715,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,577,690.37	35,161,655.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,087,000.00	20,496,910.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,287,000.00	19,996,910.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	94,490,690.37	14,664,745.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,490,690.37	14,664,745.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>44,995,000.00</u>	<u>12,600,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,715,000.00	12,600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,715,000.00	12,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	24,715,000.00	12,600,000.00
222001	Тоног төхөөрөмж	8,000,000.00	12,450,000.00
223001	Бусад хөрөнгө	16,715,000.00	150,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(24,715,000.00)</u>	<u>(12,600,000.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,280,000.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү дүн	Харьцуулалт
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	876,032,100.00	850,363,345.23	25,668,754.77	98.68%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	876,032,100.00	848,725,245.23	27,306,854.77	97.24%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	851,033,800.00	816,671,435.23	34,362,364.77	95.96%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,964,200.00	565,028,908.77	3,935,291.23	99.31%
210101	Үндсэн цалин	428,959,900.00	316,976,072.57	111,983,827.43	73.89%
210102	Нэмэгдэл	107,369,800.00	215,431,608.00	(108,061,808.00)	200.64%
210104	Урамшуулал	32,634,500.00	32,621,228.20	13,271.80	99.96%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,259,400.00	74,399,635.29	859,764.71	98.86%
210201	Тэтгэврийн даатгал	52,319,680.00	52,061,722.72	257,957.28	99.51%
210202	Тэтгэмжийн даатгал	5,688,144.00	5,686,527.42	1,616.58	99.97%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,634,780.00	4,529,362.00	105,418.00	97.73%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,146,836.00	1,101,902.37	44,933.63	96.08%
210205	Эрүүл мэндийн даатгал	11,469,960.00	11,020,120.78	449,839.22	96.08%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,294,700.00	132,652,591.17	12,642,108.83	91.30%
210301	Гэрэл, цахилгаан	9,569,400.00	10,389,736.17	(820,336.17)	108.57%
210302	Түлш, халаалт	135,000,000.00	121,874,355.00	13,125,645.00	90.28%
210303	Цэвэр, бохир ус	725,300.00	388,500.00	336,800.00	53.56%
2104	Хангамж, бараа материалын зардал	8,192,700.00	7,142,700.00	1,050,000.00	87.18%
210401	Бичиг хэрэг	270,700.00	270,700.00	-	100.00%
210402	Тээвэр, шатахуун	2,467,900.00	2,467,900.00	-	100.00%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	537,500.00	537,500.00	-	100.00%
210404	Ном, хэвлэл	150,000.00	-	150,000.00	0.00%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,495,000.00	1,495,000.00	-	100.00%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,271,600.00	2,371,600.00	900,000.00	72.49%
2105	Нормативт зардал	34,639,500.00	30,747,200.00	3,892,300.00	88.76%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	198,700.00	198,700.00	-	100.00%
210502	Хоол, хүнс	29,068,900.00	25,176,600.00	3,892,300.00	86.61%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,371,900.00	5,371,900.00	-	100.00%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,654,400.00	2,204,400.00	12,450,000.00	15.04%
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,300,000.00	850,000.00	12,450,000.00	6.39%

Сэлэнгэ аймгийн Түшиг сум дахь Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	1,354,400.00	1,354,400.00	-	100.00%
2107	Томилолт, зочны зардал	182,900.00	182,900.00	-	100.00%
210702	Дотоод албан томилолт	182,900.00	182,900.00	-	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,130,700.00	2,597,800.00	(467,100.00)	121.92%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	690,700.00	1,733,800.00	(1,043,100.00)	251.02%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	864,000.00	576,000.00	60.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,715,300.00	1,715,300.00	-	100.00%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,715,300.00	1,715,300.00	-	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,998,300.00	35,161,655.94	(10,163,355.94)	140.66%
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,998,300.00	20,496,910.00	4,501,390.00	81.99%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,498,300.00	19,996,910.00	4,501,390.00	81.63%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.00%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	12,600,000.00	(12,600,000.00)	
2200	Дотоод эх үүсвэрээр	-	12,600,000.00	(12,600,000.00)	
222001	Тоног төхөөрөмж	-	12,450,000.00	(12,450,000.00)	
223001	Бусад хөрөнгө	-	150,000.00	(150,000.00)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	876,032,100.00	865,028,091.17	11,004,008.83	98.74%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	730,737,400.00	732,375,500.00	(1,638,100.00)	100.22%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	730,737,400.00	730,737,400.00	-	100.00%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	145,294,700.00	132,652,591.17	12,642,108.83	91.30%
132001	Орон нутгийн төсвөөс	145,294,700.00	132,652,591.17	12,642,108.83	91.30%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,638,100.00	(1,638,100.00)	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		595,000.00	(595,000.00)	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,043,100.00	(1,043,100.00)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	48.00	48.00	-	100.00%
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	27.00	-	100.00%
620003	Үйлчлэх ажилтан	18.00	18.00	-	100.00%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	355.00	359.00	(4.00)	101.13%
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	355.00	359.00	(4.00)	101.13%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,638,100.00	(1,638,100.00)	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,638,100.00	(1,638,100.00)	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,638,100.00	(1,638,100.00)	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-	-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	-	-	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	-	
2104	Хангамж, бараа материалын зардал	-	595,000.00	(595,000.00)	
210401	Бичиг хэрэг	-	187,000.00	(187,000.00)	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	408,000.00	(408,000.00)	
2105	Нормативт зардал	-	-	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	-	
2107	Томилолт, зочны зардал	-	-	-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,043,100.00	(1,043,100.00)	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	
211	ХҮҮ	-	-	-	
212	ТАТААС	-	-	-	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	595,000.00	(595,000.00)	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	595,000.00	(595,000.00)	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	595,000.00	(595,000.00)	
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,043,100.00	(1,043,100.00)	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Түшиг сум дахь Ерөнхий боловсролын сургуулийн */цаашид Түшиг сумын ЕБС гэх/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид, ахлах аудитор Ш.Ганчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түшиг сумын ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭСБ Аудит” ХХК-д 2022 оны 02 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түшиг сумын ЕБС нь тайлант онд “Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад бүх талуудтай хамтран ажиллах” гэсэн зорилтын хүрээнд 5 зорилт дэвшүүлж ажилласан. Үүнд:

1. "Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах боломж, нөхцөлийг бүрдүүлж, сургууль завсардалгүй сургах"
2. "Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, цахим болон даалгаврын сан бүрдүүлэн ажиллах".
3. "Багш, удирдах ажилтан бүр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүйгээ хөгжүүлж, хамтран ажиллах"
4. "Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж" арга хэмжээний хүрээнд сургууль, цэцэрлэг бүрийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэн, эрүүл, аюулгүй, ээлтэй орчинг бүрдүүлэх",
5. "Судалгаа, арга зүйн байгууллагуудтай хамтран ажиллаж, сургалтын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэн, сургалт, үйл ажиллагааны чанарыг сайжруулж ажиллах

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан "Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түшиг сумын ЕБС нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Бага” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 839,012.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 16,780.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 13,424.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Түшиг сумын ЕБС-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 112,062.5 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Б			
Бараа материал	61,645.2	78,092.7	16,447.5
Үндсэн хөрөнгө	2,076,264.4	2,171,879.4	95,615.0
Нийт хөрөнгө	2,137,909.6	2,249,972.1	112,062.5
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,137,909.6	2,249,972.1	112,062.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,137,909.6	2,249,972.1	112,062.5

Бараа материалын дансны үлдэгдэл 78,092.7 мянган төгрөг болж 16,447.5 мянган төгрөгөөр өссөн нь 19,996.9 мянган төгрөгийн хоол, хүнсний материал, 12,862.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 25,176.6 мянган төгрөгийн хүнсний материал, 11,717.9 мянган төгрөгийн бусад хангамжийн материал худалдан авч, 61,104.1 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,365,316.3 мянган төгрөг болж өмнөх оноос 23,290.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 12,600.0 гал тогооны тоног төхөөрөмж болон компьютер худалдан авсан, БСУГ-аас 1,597.8 төгрөгийн үнэ бүхий сурах бичиг, Улаанбаатар Төмөр замаас 4,600.0 мянган төгрөгийн ширээ сандал, БШУЯ-наас 4,492.4 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,034,817.8 мянган төгрөг болж өмнөх оноос 1,358,737.9 мянган төгрөгөөр буюу 56.7 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлого буурсантай холбоотой болно.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 923,798.3 мянган төгрөг болж өмнөх оноос 36,019.6 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Түшиг сумын ЕБС нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 1,054,022.4 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 196,357.2 мянган төгрөгөөр бууруулж, 876,032.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр **876,032.1** мянган төгрөгийн төсөв баталснаас 730,737.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 145,294.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 730,737.4 мянга, орон нутгийн төсвөөс 132,652.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд **848,725.3** мянган төгрөг зарцуулж, 14,664.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 848,725.3 мянган төгрөг буюу 96.8 хувьтай тайлагнагдсан нь бараа үйлчилгээний зардал 23,251.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардал 4,501.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас 595.0 мянган төгрөг, түрээсийн номны орлого 1,043.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, бичиг хэргийн зардалд 187.0 мянга, хог, ариутгалын зардалд 408.0 мянган төгрөг зарцуулж, БШУЯ-д номын түрээсийн номны 1,043.1 мянган төгрөгийг шилжүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын хоёрдугаар хавсралт “Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроон 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ЕБС-ийн тайлант оны үйл ажиллагаанд 876,032,1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 848,725.3 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.2 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 23,290.2 мянган төгрөгөөр шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,524.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 850.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 10,674.8 төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

- Аудитаар 850.0 мянган төгрөгийн угаалгын машиныг бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж, залруулав.

4.4 Зөвлөмж

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 7 удаагийн мэдээллийг хугацаа хоцроон, 2 мэдээллийг огт мэдээлгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

2. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

2.1. Илрүүлэлт: Тайлант онд 10,674.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.1 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу

бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Түшиг сумын ЕБС	3	11,524.8	1	850.0					2	10,674.8